


9

Үйлдвэрийн машин төхөөрөмжөөс үүдэх осол гэмтэл



Хурц, халуун эд анги эсвэл хөдөлгөөнт машин механизм, материал нь үргэлж аюул дагуулж байдаг. Олонх үйлдвэрийн ажилчид төхөөрөмжийн аюултай хэсгээс сайтар хамгаалагдаагүйгээс болж түлэгдсэн, хайрагдсан, хуруу, гар, хөлөө тайруулсан эсвэл нүдээ гэмтээсэн байдаг. Төхөөрөмжийн гэмтэл нь хөдөлмөрийн чадварыг бүрмөсөн алдуулж, тэр ч байтугай заримдаа үхэлд хүргэдэг. Эвдэрсэн төхөөрөмжөөс аюултай химийн бодис, халуун уур болон шингэн асгарч, шалыг халтирамхай болгох эсвэл ажилчдыг түлэх аюулыг бий болгодог.

Төхөөрөмжийг угсрах болон ашиглахдаа аюулгүйн хаалт хийх, ажилчдад төхөөрөмжийг аюулгүй ашиглахад болон төхөөрөмжийг хэрхэн тохируулгатай байлгах талаар сургалт хийснээр тоног төхөөрөмжөөс үүдсэн бэртэл, гэмтлээс урьдчилан сэргийлж чадна. Үйлдвэрлэх процессыг хурдасгахын тулд хаалт хамгаалалтыг авах, хурдан шуурхай ажиллахыг шаардахаас болон тогтмол үзлэг, засвар үйлчилгээ хийдэггүй эсвэл дарга нар нь шинэчлэл хийхгүй байгаагаас ажилчид гэмтэж, бэртэж байна.

Төхөөрөмжийн гэмтлээс урьдчилан сэргийлэхийн тулд:

- Ажилчдад төхөөрөмжийг хэрхэн ажиллуулах, тохируулах, үзлэг хийх талаар суралцах хангалттай хугацаа өг;
- Төхөөрөмжийн аюултай хэсгүүдэд ажилтан хэзээ ч биеийн аль нэг

хэсгээ оруулахгүй байхаар төхөөрөмжийг тохируулж, хийх ажлыг нь зохион байгуулж, загварчил;


- Ажилчдыг чухал шаардлагатай хамгаалалтын хэрэгслээр сайтар ханга;
- Төхөөрөмж нь аюултай гэмтэл бэртэл учруулахаас өмнө унтраах эрх мэдлийг ажилчдад өг.

Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа


Бүх ажилчдыг өөрсдийн төхөөрөмжийг хэрхэн аюулгүй ажиллуулах талаар сургалтад хамруулах хэрэгтэй. Учир нь төхөөрөмжийг ажиллуулна гэдэгт ихэвчлэн төхөөрөмжийг засварлах, цэвэрлэх, тохируулга хийх ажил ордог тул тэдгээрийг хэрхэн аюулгүй гүйцэтгэх талаар заавал сургалтад хамруулсан байх ёстой.

Хавчуулагдсан зүйлс, өөдөс, хэлтэрхийг цэвэрлэх


Хэрэв машин гацаж, тоног төхөөрөмжийн дотор байгаа өөдөс хэлтэрхийг гаргах болбол нэн хянуур, болгоомжтой хандах хэрэгтэй. Гэмтэл бэртлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг ав. Таарч тохирох багаж хэрэгсэл байхгүй, аль эсвэл байгаа хэрэгслээрээ цэвэрлэх боломжгүй байгаа тохиолдолд аюултай хэсэг рүү орохоос өмнө заавал машин төхөөрөмжийг унтрааж, түгжиж, тусгаарласан байх ёстой. Хэрэв төхөөрөмжийг унтрааж, зогсоох талаар сурч мэдээгүй бол дур мэдэн гацааг арилгах, өөдөс хэлтэрхийг цэвэрлэх гэж оролдох хэрэггүй. Үүний оронд тухайн тоног төхөөрөмжийг аюулгүй засварлахад сурч мэргэшсэн ажилтнаас тусламж ав.



Туршлагатай ажилчин шинэ ажилчныг төхөөрөмж дээр хэрхэн аюулгүй ажиллах талаар сургаж болно



Төхөөрөмжийг цэвэрлэхдээ гараар биш, багаж хэрэгсэл ашигла.



Туршлагатай ажилчид төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны горимыг хэнээс ч илүү сайн мэддэг. Тэд гарга эсвэл бусад ажилчдад төхөөрөмжийн аюултай хэсэг ба хаана нь хаалт болон бусад хамгаалалт хэрэгтэй байгааг харуулж чадна.

Төхөөрөмжийн гэмтлээс ажилчдыг хамгаалах

Төхөөрөмжийн хамгаалалт нь ажилчдын биеийн хэсэг эсвэл түүний хувцас орооцолдох, хөдөлгөөнт хэсэгт зүсэгдэх, халуун хэсэгт болон материалд түлэгдэх болон салж унах, хийсэх хэсгүүдээс болж гэмтэхээс урьдчилан сэргийлдэг.

Төхөөрөмжийн аюултай хэсэгт хамгаалалт хий:


- **Хаана төхөөрөмж ажиллаж байна?**

Төхөөрөмжийн тасдах ир, хөрөөний ир, хутга, хурц үзүүр зэрэг дамжлагын төхөөрөмжид ослоос хамгаалсан хаалт хий. Хэрэв төхөөрөмжийн хөдлөх хэсэгт заавал гараа тавих шаардлагатай байдаг бол ажилтан гараа оруулах үед автоматаар унтрах урьдчилан сэргийлэх хийц, загварчлал байх хэрэгтэй. (262-266 дугаар хуудсыг үзнэ үү);

- **Цахилгаан хаагуур дамжиж байна вэ?**

Бүслүүр, гинж, эрчлүүр, дармар, холбогч, нударга, тэнхлэг, араа, үет хөшүүрэг болон бусад төхөөрөмжийн нэг хэсгээс нөгөөд эрчим хүч дамжуулах хэсгүүдэд хаалт хийх хэрэгтэй. Үгүй бол ажилчдын үс, хувцас эдгээр хөдөлгөөнт хэсэгт орооцолдон бяцлагдаж болно.

Хоёр хөдөлгөөнт хэсэг, зуух хэсэг гэх мэт аюултай хэсгүүд мөн хамгаалагдсан байх хэрэгтэй. Жишээлбэл, дармар нь холбогчтой



Хурц иртэй тасдагчийн хутганд хаалт хэрэгтэй



Зуух хэсэгт биеийн хэсэг эсвэл үс хавчуулагдаж болох тул хаалт хэрэгтэй.

залгагдах хэсэг, 2 араа зуух хэсэг эсвэл 2 өнхрүүл хамт эргэлдэх тэр хэсгүүд юм.

Мөн оролт, гивлүүр, сул хувцас өмсөж зүүхгүй эсвэл бөгж, үнэт эдлэл, бугуйвч, урт гинж, хүзүүний зүүлт, ээмэг зэрэг үнэт эдлэл хэрэглэхгүй байснаар төхөөрөмжийн хөдөлгөөнт хэсэгт орооцолдон гэмтэж бэртэхээс урьдчилан сэргийлж чадна. Урт үсээ боох эсвэл хаалт хийснээр төхөөрөмжид орооцолдохоос сэргийлнэ;

- **Хаана хагархай зүйл агаарт шидэгдэхээр байна.** Тасдагч, таслах багаж хэрэгсэл, цахилгаан хөрөө, тасдагчийн дамар, зүлгүүрийн бүслүүр, тавлах багаж зэрэг нь үүнд багтана;

- **Хаана бүрдэл хэсгүүд хугарч эсвэл хагарахаар байна.** Оёдлын машины зүү хугарах эсвэл тасдагчийн дамар нь хагарснаар нүд гэмтээх, бие махбодыг гүн гэмтээх, бүүр үхлийн шарх авах шалтгаан болдог;

- **Хаана төхөөрөмж болон материал халж байна.** Халах хэсэг, халах материал буюу уурын индүү, хатаах зуух, цутгах болон шахах төхөөрөмж, гагнуурын аппарат зэрэг нь ажилчдын хувцас эсвэл арьсыг түлж болох тул хаалт, хамгаалалт хэрэгтэй. Мөн түүнчлэн халуун материал буюу




Тасдагчийн дамарт хаалт хэрэгтэй.

хайлмал хуванцар, металл, будагч эсвэл хүчлийг үйлдвэрлэлдээ ашигладаг бол тэдгээр нь төхөөрөмжөөс асгарч буюу цацарч болно.

Төрөл бүрийн хаалт, хамгаалалт байдаг ч тэдгээрийн аль нь ч бүх төхөөрөмж, бүх ажлын байрыг төгс хамгаалахгүй билээ. Ажилчид үйлдвэрлэлийн үед, шинэ бүтээгдэхүүн хийх, дахин боловсруулах эсвэл төхөөрөмжийг хэрэглэх үед болон тохируулга хийх, гацсан хэсгийг янзлах бүхий л үед хамгаалагдсан байх ёстой.


Ажлын байранд байгаа бүх хаалт, хамгаалалт ажиллагаатай эсэхийг тогтмол үзэж, шалгаж байх хэрэгтэй.




Энэ ажилчныг гэмтэхээс хамгаалахын тулд ажлын байрыг та хэрхэн өөрчлөх байсан бэ?

Тогтмол хамгаалалт


Тогтмол хамгаалалт нь төхөөрөмжөөс эвдэрсэн хэсгүүд хийсэх эсвэл аюултай хэсэгт ажилчдын бие ойр байхаас урьдчилан сэргийлэх хамгаалалт юм.



Тасдагч хөрөөнөөс хамгаалагдсан хийцтэй бээлий



Оёдлын машины хаалт



Хувцас хэвлэх төхөөрөмжийн хаалт

Зүүний хаалтыг удирдлагадаа хэлж шинэчлүүлэв

Намайг Сецилиа гэдэг. Би Мексикийн хувцасны томоохон үйлдвэрт ажилладаг. Манай үйлдвэрийн ажилчид олон жил зохион байгуулалтад орж ажилласны дүнд өдөр бүр өөрсдийн ажлын байрыг бүгдэд аюулгүй, илүү сайн болгож чадсан юм. Бид даргатайгаа сайн харилцаатай байдаг. Ажлын байраа илүү аюулгүй болгохын тулд тавьсан хүсэлт түүнд ч ашиг тустай байдаг тул тэр биднийг сайн ойлгодог. Гэвч тэр биднийг өөрт нь тааламжтай биш байсан


ч илүү сайн нөхцөлийн төлөө тэмцэхээр нэгдэж, бас хүчтэй болсныг харсан байв.

Заримдаа дарга бидний шаардлагыг эсэргүүцэхийн оронд тэр даруй хүлээн зөвшөөрдөг. Ингэж л бид зүүний шинэ хаалтыг төхөөрөмждөө хийлгэж авсан юм.

Манай бүх төхөөрөмж хуруу зүүнд хавчигдахаас хамгаалсан хамгаалалттай. Гэвч энэ нь ойр ойрхон эвдэрчихдэг. Эхэндээ зүүний хаалт эвдэрчихдэг боловч бид оёсоор л байсан. Бид заавал үйлдвэрлэлийн нормоо биелүүлэх ёстой

ба ажлаа зогсоовол тухайн өдрийн урамшууллаа алдахад хүрдэг. Дарга биднийг зүүний хаалтгүй ажиллаж байгааг хараад “Тэд үүнгүйгээр ажиллаж чадаж байна, тэдэнд энэ хэрэггүй юм байна” гэж бодоод дахиж шинэчлэхээ больсон. Гэвч зүүний хаалтгүйгээр хэд хэдэн ажилчин хуруугаа маш хүнд гэмтээсэн юм.

Бид одоо л ямар нэг зүйл хийх хэрэгтэй байна! Бид маш хүчтэй оёдлын машин дээр их хурдтай ажилладаг тул зайлшгүй хамгаалалт хэрэгтэй гэж үзсэн. Гэмтсэн ажилчид энэхүү арга хэмжээг удирдсан юм. Эвдэрсэн бүх хаалт шинэчлэгдэх ёстой, мөн эвдрэх бүрт нь яаралтай шинэчилж байх төлөвлөгөө гаргахгүй бол суулт зарлах болно гэдгээ бид даргадаа хэлсэн. Биднийг суулт зарлах юм бол их мөнгөний алдагдалд орох бөгөөд гэмтсэн ажилчдын эрүүл мэндийн төлбөр төлөхийг хүсэхгүй байгаагаа дарга мэдэж байсан. Үүний хажуугаар зүүний хаалт нь хямдхан учир шинэчлэхэд хялбар байсан. Тиймээс тэр бүх хаалтыг бүх төхөөрөмжид тохируулан суурилуулж, илүү гарсныг нь хадгалсан. Одоо зүүний хаалт эвдрэхэд бид тухайн өдөртөө засуулж чаддаг болсон. Энэ өөрчлөлтийг хийснээс хойш нэг ч ажилчин зүүнд хуруугаа ноцтой гэмтээгээгүй юм.



Тохируулдаг хамгаалалт

Зарим хамгаалалтыг өөр өөр материалд хэрэглэхдээ тохируулж болохоор хийсэн байдаг. Гэхдээ зөвхөн зөв тохируулсан хамгаалалтыг хэрэглэсэн үед л хаалт ажилчдыг хамгаалдаг. Тохируулж болдог учраас тэдгээрийг амархан салган авч болно. Үйлдвэрлэлийн зорилгод хүрэх, ажлаа хурдасгахын тулд дарга чинь хамгаалалтыг салгах буюу хориглож болох ба даргаараа ийм аюултай зүйлийг битгий хийлгээрэй. Тохируулгыг хийхдээ цаг гаргаж хуруугаа болон амь нас, эрүүл мэндээ хамгаалаарай.



Харилцан хамааралтай хамгаалалт

Харилцан хамааралтай хамгаалалт нь төхөөрөмж зохих ёсоор байрандаа байхгүй бол шууд унтраахаар хийгдсэн байдаг. Тиймээс ажилчин төхөөрөмжийг аюулгүй тохируулж эсвэл цэвэрлээд хамгаалалтыг дахин байрлуулан аюулгүйгээр дахин асааж болдог. Харилцан хамааралтай хамгаалалтыг салгаснаар төхөөрөмжийг засварлахад аюулгүй болох учир заавал бүрэн унтраах, салгах зайлшгүй шаардлагатай байдаг (270-271 дүгээр хуудсыг үзнэ үү).



Хөдөлгөж болдог хаалт, хашлага

Зарим төхөөрөмж зөвхөн унтарсан үед нь онгойлгож, шинэ материал нэмж болдог хаалт, хашлагатай байдаг. Ингэсэн тохиолдолд хэрвээ ажилчны гар, хуруу замд нь байх үед хаалт хашлага бүрэн хаагдахгүй бол төхөөрөмж асахгүй.


Автомат унтраалгатай төхөөрөмжүүд

Онгойж, хаагддаг хаалга эсвэл нээлхийтэй төхөөрөмжүүд нь ихэвчлэн хаалга онгойх үед автоматаар унтардаг аюулгүйн удирдлагатай байдаг. Автомат унтраалгыг үргэлж хэвийн ажиллагаатай байгаа эсэхийг тогтмол шалгаж, баталгаажуулж байх ёстой.

Хоёр гарын удирдлага

Хоёр гарын удирдлагатай төхөөрөмж зөвхөн хоёр товчлуурыг зэрэг дарсан үед л ажиллаж эхэлдэг. Эдгээр удирдлага нь тусдаа байдаг тул дарахын тулд заавал хоёр гараа ашигладаг.

Ажилчинд ийм удирдлага аюулгүй боловч дэргэд нь ажиллаж байгаа ажилчид хөдөлгөөнт хэсэгт хавчуулагдахгүй байхаас урьдчилан сэргийлж чаддаггүй.




Хэвлэгчийг хаахын тулд ажилчин заавал хоёр гараа ашиглах ёстой

Гэрлийн хөшиг ба объект мэдрэгчтэй шалны дэвсгэр

Гэрлийн мэдрэгч нь олон эгнээ гэрлээс бүрдэх ба ажилчин төхөөрөмжид хэт ойртох үед мэдрдэг. Гэрлэн хөшигийн хязгаарыг давах үед төхөөрөмж автоматаар унтардаг.

Объект мэдрэгчтэй шалны дэвсгэр нь хэн нэгэн түүн дээр гишгэсэн даруйд автоматаар төхөөрөмжийг унтраадаг.


Гэрлэн хөшиг болон объект мэдрэгчтэй шалыг төхөөрөмж ажиллахаа болих хүртэл аюултай бүсэд хүрэхээргүй байхаар тооцож төхөөрөмжөөс хангалттай хол зайд байрлуулах ёстой.



Гэрлэн хөшигтэй төхөөрөмж

Халхлагдсан хөлийн гишгүүр

Олон төхөөрөмж нь хөлийн гишгүүрт хэн нэгэн гишгэснээр ажиллаж эхэлдэг. Хэрэв ажилчны гар төхөөрөмж дотор байх үед хэн нэгэн санамсаргүйгээр гишгэх юм уу, эд юм унагаавал төхөөрөмж ажилладаг. Хөлийн гишгүүр дээгүүр хамгаалалтын хаалт байрлуулснаар ийм зүйлс тохиолдохоос урьдчилан сэргийлж чадна.




Хязгаарлагч болон татах хэрэгсэл

Хязгаарлагч бүс нь ажилчны бугуйд бэхлэгдээтэй байдаг ба аюултай хэсэгт түүний гар хүрэхээс үргэлж хамгаалж байдаг. Татах хэрэгсэл нь зөвхөн төхөөрөмж унтарсан үед аюултай хэсэгт материал нэмэхээр гараа оруулах боломжийг олгодог. Төхөөрөмж асах үед бүс нь гарыг аюултай хэсгээс татдаг.

Хязгаарлагч болон татах хэрэгсэл нь өөр өөр ажилчид төхөөрөмжийг ажиллуулах бүрт тохируулга хийгдэх ёстой.

Зарим оронд хязгаарлагч болон татах хэрэгслийг онцгой байдал гарсан үед төхөөрөмжийг яаралтай орхиж явахад хэцүү болгоно гэж үзсэн учраас хориглосон байдаг. Энэ нь тун буруу юм.




Ажилчдыг хувийн хамгаалах хэрэгслээр хамгаалах

Дарга нь ажилчдаа тоног төхөөрөмжөөс хамгаалахад тус болох хувцас, хамгаалах хэрэгслээр хангах ёстой. Эдгээр нь байлаа гээд тоног төхөөрөмжийн хаалт хамгаалалтыг орлохгүй юм.

Нүүр, нүдээ хамгаалах. Нүүрний хамгаалалт, нүдний шил нь шидэгдсэн хэлтэрхий, эвдэрсэн хэсгүүд ба химийн бодис цацрах үед, аль эсвэл халуун зүйлсээс хамгаална. Хэрэв халуун материалтай ажилладаг бол халуунд хайлахгүй, шатахгүй эсвэл хагарахгүй материалаар хийсэн нүүрний хаалт хэрэглэ. Нүүрний хаалт эсвэл нүдний шилээ тайлсан үедээ толгойгоо урагш тонгойлгох бол нүдээ аньж халуун зүйлс, үртэс зэргийг нүд рүүгээ орохоос сэргийлээрэй. Малгай, үсний боолт болон үсний бүрхүүл зэрэг нь хөдөлгөөнт тоног төхөөрөмжид хавчуулагдахаас хамгаална.

Гараа хамгаалах. Бээлий хэрэглэ. Төмөр сараалжин бээлий нь хутганы ирэнд гараа зүсэхээс хамгаалдаг. Арьсан эсвэл нэхмэл бээлий болон ханцуй нь арьсыг хурц үзүүртэй зүйлсээс хамгаална. Хэрвээ халуун тоног төхөөрөмж, материалтай ажилладаг бол арьсан болон арьсанд халуун дамжуулахгүй, хайлахгүй, гал гарахааргүй материалаар хийсэн бээлий өмс. Хэрвээ хөдөлгөөнт хэсгүүдтэй тоног төхөөрөмж дээр ажилладаг бол тоног төхөөрөмжид хавчигдан сугарахааргүй бариу бээлий хэрэглэ. Бээлий нойтон болох эсвэл химийн бодист өртвөл үргэлж бээлийгээ сольж бай.



Халуун материалтай ажиллахдаа багаж хэрэглэ.

Бие болон хөлөө хамгаалах. Битүү тусгаарлагч болон хормогч ашиглан өөрийн хувцас, арьсанд химийн бодис, тоос тоосонцор хүрэхээс хамгаал. Хувцас нь хөдөлгөөнт хэсэгт хавчуулагдахаас хамгаалахад тус болно. Арьсан, ноосон, брезентэн буюу амархан шатахааргүй эсвэл хайлахааргүй материалаар хийгдсэн урт, битүү гутал хувцас өмс. Хэрвээ та халуун шингэн зүйлс буюу химийн бодис эсвэл электролизийн бүрэлтийн ваннтай харьцаж ажилладаг бол зузаан резин хормогч болон гутал хэрэглэснээр химийн бодис цацрах, хувцас шатахаас хамгаална.

Өөр өөр төрлийн хувийн хамгаалах хэрэгслийн талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл 18-р бүлгийг үзнэ үү.

Тоног төхөөрөмжийг аюулгүй засварлахын тулд цоожилж, пайз зүүх

Тоног төхөөрөмжийн гацалт, эвдрэлийг засдаг ажилчид нь илүү аюултай хэсэгт орж ажиллах ёстой болдог тул нэмэлт хамгаалалт хэрэгтэй. Засвар хийж байх үед тоног төхөөрөмж асах, хөдөлж эхлэхээс урьдчилан сэргийлэхийн тулд тэдэнд цаг хугацаа, сургалт, мөн багаж хэрэгтэй:

- **Төхөөрөмжийг цоожилсноор** тоног төхөөрөмж нь гэнэт асах эсвэл хөдлөх боломжгүй болно. Тоног төхөөрөмжийг засварлаж байх үед тогноос нь салга. Мөн хөтлөх голыг сольж байх үед ажиллаж эхлэхээс сэргийлж холбоотой бүх бүслүүрийг салгах хэрэгтэй;
- **Тоног төхөөрөмжийг хааснаар** ус, химийн бодис эсвэл бусад материал урсаж орж ирэхээс бүрэн хамгаалах ба зөвхөн унтраасан үед засвар үйлчилгээ, тохируулга хий. Мөн хуримтлагдсан энерги, электроны хэсгүүд буюу конденсатор, түүнчлэн поршень, хоолой, шугаманд үүссэн агаарын болон усны даралт зэргийг бүгдийг нь гаргасан эсвэл хаасан байх ёстой;
- **Тоног төхөөрөмжийг пайзласнаар** бусад ажилчдад цахилгааны дамжуулагч, бүслүүр нь тодорхой зорилгоор салгагдсан тул түүнд саад болохгүй орхисон нь дээр гэдгийг мэдэхэд тустай.

Ажил олгогч нь цоожлох буюу пайзлах үед шаардлагатай зүйлсээр ханган тодорхой дэг журам тогтоох үүрэгтэй.

Цоожлох зааварчилгаа

Үйлдвэрүүд тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийх үед ажилчид гэмтэж бэртэх эсвэл амиа алдах аюулаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөтэй байх хэрэгтэй. Төхөөрөмжийг цоожлох төлөвлөгөөнд дараах зааварчилгаа орно:

- Тоног төхөөрөмжийн бүх л энергийн эх үүсвэр бүрэн салгагдаж, хаагдаж, түгжигдэхээс нааш ажилчид хэзээ ч засвар үйлчилгээ эсвэл тохируулга хийж болохгүй. Ингэснээр тоног төхөөрөмж санамсаргүйгээр асахаас урьдчилан сэргийлнэ;
- Засварын ажилтан нь цоожинд нэмэлтээр шошго зүүхдээ цоожийг хэн хариуцаж байгаа, бусад ахлах болон ажилчдад дахин залган асааж болохгүй гэдгийг анхааруулсан, яагаад энэ тоног төхөөрөмж цоожтой байгааг илтгэсэн мэдээллийг бичсэн байна;
- Засварын ажилтан нь цоожинд таарах цорын ганц түлхүүртэй байх ба зөвхөн тэр л цоожийг тайлж, шошго болон хаалтыг авч, тогонд дахин залгаж болно;
- Хэрэв нэгээс олон засварын ажилтан тоног төхөөрөмжийг засаж байгаа

бол ажлаа дууссаны дараа тус бүр өөр өөрсдийн түлхүүр шошгыг авч байна;


- Бүх ажилчид нь цоожлох журам хэрэглэж байгаа шалтгаан, яагаад эдгээр журмыг анхаарч байх талаар сургалтад хамрагдсан байна.

Тоног төхөөрөмжийн зааварчилгааг анхааралтай үзэх

Зарим үйлдвэр нь олон төрлийн тоног төхөөрөмжтэй байх ба тэдгээр нь хэд хэдэн загвартай байдаг. Тоног төхөөрөмж бүрийг аюулгүй засварлахын тулд бүгдийг нь хэрхэн салгах болон хаалт хийх талаар сайн мэддэг байх хэрэгтэй. Тоног төхөөрөмж бүрт өөрийн хувийн цоож болон хаалтыг зөв хийх талаар зурагт зааварчилгааг байлгаснаар ажилчид засварыг зөв хийж байгаадаа итгэлтэй байхад тусална.

Хаалт, хамгаалалт болон аюулгүйн бусад хэрэгслийг дахин угсрах

Тоног төхөөрөмжийн механикч болон засвар үйлчилгээний ажилчид нь тоног төхөөрөмж дээр ажиллаж байхдаа зарим үед хаалт, хамгаалалт болон аюулгүйн бусад хэрэгслүүдийг салгадаг. Тоног төхөөрөмжийн хаалтыг авах, тогонд залгахаасаа өмнө хаалт, хамгаалалт болон аюулгүйн бусад хэрэгслийг үргэлж дахин угсарч бай.



Тоног төхөөрөмжийг засварлаж эхлэхээсээ өмнө үргэлж цоожилж, хаалт хийж, пайз зүүж бай.



Анхны
тусламж

Үйлдвэрийн машинаас үүдэлтэй осол гэмтэлд үзүүлэх анхны тусламж

Тоног төхөөрөмжөөс үүсэх ихэнх гэмтлүүд ноцтой байдаг ба тэр даруй эмчийн тусламж авах хэрэгтэй байдаг. Хэрвээ эмнэлгийн ажилтан тэр бүр хурдан ирж чадахааргүй бол гэмтсэн ажилтныг хамгийн ойрхон эмнэлэг, түргэн тусламжид хүргэ. Явах замдаа түүнийг хэвтүүлэн авч яв. Энэ үед:

Шоконд орж байгаа эсэхийг харах: Ямар ч төрлийн гэмтэл авч, их хэмжээний цус алдаж байгаа хүн шоконд орж, амиа алдаж болно. Дотуур цус алдалтыг харж чадахгүй ч мөн адил шоконд орох шалтгаан болдог.

Шоконд орж байгааг илтгэх шинж тэмдгүүд: Биеийн байдал сул дорой, зүрхний цохилт түргэссэн, царай зэвхий цайсан, хүйтэн, чийгтэй арьстай, мэдрэл дорой, ухаан балартсан болон муужирсан.

Шоконд орсон үед эмчлэх ба түүнээс урьдчилсан сэргийлэх: Тухайн хүнийг хажуу талаар нь хэвтүүлэх ба хөлийг нь зүрхний түвшнээс өндөрт байлга. Цус алдалтыг зогсоо. Хэрэв огиж бөөлжвөл тэр даруй амыг нь цэвэрлэ. Хөнжлөөр дулаан хуч. Хэрэв сэргэвэл балга ус өг.

Гараа цус болгохоос

хамгаалах: Гялгар цаас, резин бээлий өмс эсвэл гартаа уут угла. Цус нь вирус, гепатит болон ХДХВ/ДОХ агуулж байж болно. Цэвэр бээлий нь шороо, вирус болон химийн бодисыг шархнаас хол байлгах болно. Гэхдээ хамгийн чухал нь цус алдалтыг аль болох хурдан зогсоож гэмтсэн хүнд туслах явдал юм.

Тодорхой төрлийн гэмтлийн үед дараах дарааллыг ашигла:



Эхлээд эмч дууд, түүнийг
ирж байх хооронд цус
алдалтыг зогсоо.

Том, гүн зүсэгдэлт эсвэл биеийн аль нэг хэсэг тасарсан үед:

Юуны өмнө хэвтүүл. Биеийн гэмтсэн хэсгийг өргө. Бээлийтэй гараараа шархадсан хэсэгт зузаан даавуу байрлуулан дар. Цус алдалт зогстол дар. Энэ нь 15 ба түүнээс дээш минут орчим болно. Хэзээ ч шороо, керосин, лимон эсвэл кофе зэргийг цус алдалт зогсооход ашиглаж болохгүй.

Гэдэс ходоодны гүн шарх: Түүнийг хэвтүүл. Шархыг зузаан даавуугаар хуч. Уух зүйл, хоол, бүр ус ч өгч болохгүй.

Бяцарсан биеийн хэсэгт: Түүнийг хэвтүүл. Шоконд орж байгаа эсэхийг хар.

Ямар нэг зүйл биед зоогдсон

бол: Хэрэв төхөөрөмжийн хэсэг эсвэл ямар нэг зүйл ажилтны биед гүнзгий зоогдсон бол тухайн зүйлийг биед нь байгаа чигээр нь байлгаж, эмч ирэхийг хүлээ эсвэл эмнэлэгт хүргэ. Тухайн зүйл ямар нэг том эсвэл хүнд зүйлтэй холбогдсон бол тухайн зүйлээс салгахыг оролд, гэхдээ орсон зүйлийг татах эсвэл илүү гүн биед оруулж болохгүй. Хэрэв тэр цус алдаж байвал зузаан цэвэр даавуугаар тухайн хэсэгт дар. Цус алдалт зогстол дар.

Нүдний гэмтэл: Түүнийг хэвтүүлж, шархыг цэвэр даавуугаар бүтээ. Хэрэв түүний нүдэнд ямар нэг эд зүйл, утас, хуванцар эсвэл төмөр байна гэж үзвэл 15 минутын турш усаар угаа. Хэрэв ямар нэг зүйл нүдэнд зоогдсон бол түүнийг сугалж гаргаж болохгүй. Түүнийг эмнэлэгт хүргэтлээ нүдэнд нь хэвээр нь байлга.

Толгойн гэмтэл: Гэмтсэн хүний цээж болон толгойг нь хагас өргөж, суугаа байдалд байлга. Толгой болон цээжийг даавуу, бүтээлэг, дэр эсвэл хувцсаар дэмнэж өг. Шархыг цэвэр даавуугаар хуч.

Зүсэгдэх болон шалбарах: Шархыг маш их усаар угаа. Шарханд шороо тоос орох нь халдварын шалтгаан болно. Зүсэгдсэн хэсэг дэх цэвэр даавуу эсвэл бинтийг өдөр бүр сольж боож бай.



Бараг бүх шархны чанх дээр нь дарвал цус алдалт зогсох болно. Гэвч та тэвчээртэй байх хэрэгтэй. Энэ нь цаг их шаардана.



Анхны
тусламж

(үргэлжлэл)

Анхны
тусламж

Түлэгдэх: Түлэгдсэн биеийн хэсгийг гоожиж буй усны урсгал доор дор хаяж 15 минут байлга. Халуун тоног төхөөрөмж эсвэл материалаас болсон түлэгдэлт нь галд түлэгдсэнтэй ихэвчлэн ижил эмчилгээтэй байдаг (Түлэгдэлтийн үед үзүүлэх анхны тусламжийг 289-290 дүгээр хуудаснаас үзнэ үү).

Гэмтсэний дараа цэвэрлэх: Нэгэнт гэмтсэн хүнд арга хэмжээ авсны дараа эргэн тойрны бүх хүмүүс өөрсдийн арьс эсвэл үсэн дэх цусыг савантай усаар сайтар угаах хэрэгтэй. Цус болсон хувцсыг тайлуулж, угаах хүртэл уутанд хийж байлга. Ажлын газрын цус болсон хэсгийг резин бээлий өмсөн, вирус устгагчтай цэвэрлэгч бодис, мөн цайруулагчтай эсвэл хлортой усаар цэвэрлэ. Цустай даавууны өөдөс, бинтийг гялгар уутанд хийж, амыг нь уяж хогийн саванд хий.

Хэрэв таны нүд рүү гэмтсэн хүний цус орсон бол эмчид хэл. Магадгүй гепатитийн вакцин эсвэл (ХДХВ/ДОХ) өртөлтийн дараах урьдчилан сэргийлэх вакцин хэрэгтэй байж болно (30-р бүлгийг үз).